



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/55

Хажуу шинэ-Ус

Зуны цагийн хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн А/490 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Худалдаа үйлчилгээний аж ахуй нэгж байгууллагуудын ажиллах цагийн хуваарийг зуны цагийн хуваарьт шилжүүлсүгэй.

2.Худалдаа үйлчилгээ явуулдаг дэлгүүрүүдийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл өглөө 09:00 цагаас оройн 21:00 цаг хүртэл ажиллахаар тогтоосугай.

3.Найман нэрийн дэлгүүрүүд сар бүрийн нэгэнд архи, согтууруулах ундаагаар үйлчлэхийг хориглосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч (Э.Ванчиндорж), Хэсгийн цагдаа (Б.Наранбаатар), Өрнөлт багийн Засаг дарга (Л.Батбаатар) нарт үүрэг болгосугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/40 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Т.АРИУНАА

482401054